

ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

ҮАГ-ын Нийцлийн Аудитын газрын 2014 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан

Иргэн бүрт олгох 1.0 сая төгрөгийн хишиг хувийг оюутан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан иргэдэд олгосон нь Төв аймгийн нийт иргэдийн 33.4 хувийг эзэлж байна.

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u> ҮАГ-ын харьяа Төв аймгийн Аудитын газар Аймгийн Тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан Аудитын менежер О.Амаржаргал Аудитор Ц.Саранчимэг 2014 оны 05 дугаар сарын 01 Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү. Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70273204 дугаарын утас, 70272582 дугаарын факсаар харилцана уу ХАЯГ:Төв аймгийн Төрийн байгууллагын ордон	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....3 Аудитын дүн.....4-9 Бүлэг 1 Хүний хөгжил сангийн 2013 оны Төсвийн тухай хуулийн 3-д заасан 329275.2 сая төгрөгийн орлогыг Төв аймгийн төвлөрүүлэх орлоготой харьцуулбал 0.04 хувийг бүрдүүлэхээр байна. Бүлэг 2 Хүний хөгжил сангаас давхардсан тоогоор 252499 иргэнд 2010-2013 онуудад нийт 56747.6 сая төгрөгийг бэлэн мөнгө хэлбэрээр, 26467 иргэнд 4985.5 сая төгрөгийн хишиг хувь бэлэн бус хэлбэрээр олгосон байна. Бүлэг 3 2013 онд Хүний хөгжил сангийн олголт, зарцуулалтын байдалд дотоод хяналт болон хөндлөнгийн хяналт хийгдээгүй байна. Дүгнэлт.....10 Зөвлөмж.....11 Холбогдох байгууллагын санал: Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал12 Саналд өгсөн тайлбар
---	---

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1.1 Аудит хийсэн үндэслэл

Төрийн Аудитын тухай хуулиар тодорхойлогдсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

1.2 Аудитын зорилт , хамарсан хүрээ

Хүний хөгжил сангийн үйл ажиллагаа үр дүнтэй явагдаж буй эсэх талаар дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж цаашид авах арга хэмжээг эрчимжүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараахь дэд зорилтын дагуу аудит хийлээ.

- Хүний хөгжил сангийн хөрөнгийн төлөвлөгөөг хууль тогтоомжтой уялдуулан төлөвлөсөн үү?
- Хүний хөгжил сангийн хөрөнгийг хуулийн хүрээнд зөв зарцуулж байна уу?
- Сангийн хөрөнгийн зарцуулах бодлого, үйл ажиллагаанд тавих хяналт үр дүнтэй байна уу?

Аудитад Төв аймгийн 27 сум, аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Хүний хөгжил сангийн хөрөнгө байршиж буй Төрийн сан болон арилжааны банкнуудын данс 2013 оны байдлаар бүрэн хамрагдлаа.

1.3 Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

1. Монгол улсын Үндсэн хууль
2. Төсвийн тухай хууль
3. Хүний хөгжил сангийн тухай хууль
4. Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хууль
5. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
6. МУИХ-ын 2010 оны 76-р тогтоол
7. ЗГ-ын 2010 оны 3-р тогтоол
8. ЗГ-2010 оны 347-р тогтоол
9. ЗГ-ын 2011 оны 264-р тогтоол
10. Дээрх тогтоолуудтай нийцүүлж гаргасан журмууд

Аудитыг Төв аймгийн Аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал удирдан, аудитор Ц.Саранчимэг 2014 оны 04 –р сарын 20-ноос 05-р сарын 01-ныг дуусталх хугацаанд хийж гүйцэтгэв.

Бүлэг 1

Хүний хөгжил сангийн 2013 оны Төсвийн тухай хуулийн 3-д заасан 329275.2 сая төгрөгийн орлогыг Төв аймгийн төвлөрүүлэх орлоготой харьцуулбал 0.04 хувийг бүрдүүлэхээр байна.

1.1 Хүний хөгжил сангийн хөрөнгийн төлөвлөгөөг хууль тогтоомжтой уялдуулан төлөвлөснийг улсын хэмжээнд дүгнэлт өгөх боломжтой байна.

Хүний хөгжил сангийн орлогын эх үүсвэр бүрдүүлэхэд Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.2-т “Ашигт малтмалын орд газарт ашигт малтмал олборлох, боловсруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 70 хувь”-аар бүрдүүлэхээр заасан байна.

Аймгийн хэмжээнд 638962.77 га газрыг хамарсан 448 тусгай зөвшөөрөл олгогдсоноос 63140.14 га талбай хамарсан 228 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ба 2013 оны байдлаар 17157.35 га газар хамарсан ашиглалтын 94 тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 47.1 “Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг улсын төсөвт төлнө” гэснийг үндэслэн алтны нөөцийн төлбөрийг шууд Сангийн яаманд төвлөрүүлж аймагт төлөвлөдөггүй бөгөөд Төв аймгийн хэмжээнд 2013 онд төсвийн орлого бүрдүүлэх татварын төлөвлөгөөнд улсын төсвийн татварын орлого алтнаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр 9 ААНБайгууллагаас 188.8 сая төгрөгийн орлого оруулахаар батлагдсан байна. Энэ нь Хүний хөгжил сангийн тухай хуулиар заасан эх үүсвэрийг бүрдүүлэхэд орлогын 70 хувиар тооцвол 132.1 сая төгрөг бүрдүүлэхээр тооцогдож байна.

Орон нутагт Хүний хөгжил сангаас санхүүжигдэх хөрөнгийн төлөвлөгөөг хийдэггүй харин Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газарт аймгийн хүний хөгжил сангаас хишиг хувь хүртэх иргэний тоогоо гаргаж, захиалга өгч ажилласан байна.

1.2 Орон нутгийн хувьд Хүний хөгжил сангийн орлогын бүрдүүлэлт хуулийн дагуу бүрэн хийгдсэн байна.

Төв аймаг 2013 онд алтнаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр гүйцэтгэлээр 469.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж төлөвлөгөөг 280.6 сая төгрөгөөр буюу 2.5 дахин давуулан биелүүлсэн байна.

№	Сумдын нэрс	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
1	Баян	4000.0	8368.3	209.2
2	Баяндэлгэр	3000.0	79898.8	2663.3
3	Баянцагаан	178842.6	290000.0	162.2
4	Баянчандмань	3000.0	68479.6	2282.7
5	Эрдэнэ		6152.2	100.0
6	Зуунмод		16533.9	100.0
	Нийт дүн	188842.6	469432.8	248.6

1.3 Зарим арилжааны банкин дахь сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд олгох хүүгийн орлогын төвлөрүүлэлт зохих журмын дагуу явагдсан байна.

Сангийн дэд сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд, ХААН банкны захирал, Хадгаламж банкны захиралтай Хүний хөгжил сангаас хишиг хувийн мөнгийг иргэдэд олгох үйлчилгээний тухай гэрээг 2012 оны 01-р сарын 16-ны өдрийн №23/03/05/101 тоот гэрээ хийсэн байна.

Энэхүү гэрээнд харилцах дансны үлдэгдэлд хэмжээ харгалзахгүйгээр сар бүр 0.3 хувийн хүүг тооцуулан тухайн сарын эцэст татвар суутгаагүй дүнгээр харилцах дансандаа хүүгийн орлогыг оруулахаар тусгасан байна.

2013 онд дээрх гэрээний дагуу Хаан банкны хувьд 1-12 сарын хугацаанд, Хадгаламж банкны хувьд хүүгийн орлогыг улирлаар хийж нийт 2.1 сая төгрөгийн хүү бодогдсон байна.

Хүний хөгжил сангийн харилцах дансанд орсон хүүгийн орлого

№	ХААН банк		Хадгаламж банк		Нийт дүн
	Дансны дугаар	Хүүгийн орлого	Дансны дугаар	Хүүгийн орлого	
1	5721356780	4561.74	31990006251	191850.64	196412.4
2	5721432888	898843.66	31000006637	898.33	899742
3			31990008365	991355.93	991355.9
дүн		903405.4		1184104.9	2087510

2013 онд Хүний хөгжил сангийн харилцах дансны үлдэгдэл хадгалуулсаны хүүгийн орлого 2.1 сая төгрөгийн орлогыг санхүүгийн тайлан дахь мөнгөн гүйлгээний тайланд бүрэн тусгасан байна.

Төв төрийн сангийн Хүний хөгжил сангийн дансанд 2013 оны хүүгийн орлого 2.1 сая төгрөг, өмнөх оны хүүгийн орлого дутуу тооцогдсоныг албан шаардлагаар нөхөн тооцож оруулсан 2.8 сая төгрөг, нийт 4.9 сая төгрөгийг шилжүүлж төвлөрүүлсэн байна.

Бүлэг 2

Хүний хөгжил сангаас давхардсан тоогоор 252499 иргэнд 2010-2013 онуудад нийт 56747.6 сая төгрөгийг бэлэн мөнгө хэлбэрээр, 26467 иргэнд 4985.5 сая төгрөгийн хишиг хувь бэлэн бус хэлбэрээр олгосон байна.

2.1 Хүний хөгжил сангаас хуваарилагдах хишиг хувь зохих журмын дагуу олгогдсон байна.

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын даргын Хүний хөгжил сангаас иргэн бүрт олгох хишиг хувийн 2013 оны төлөвлөгөө 32000.0 сая төгрөгөөр олгохоор төлөвлөгдсөнөөс, Төв аймагт 700.0 сая төгрөг олгохоор батлагдсан байна.

2013 онд Хүний хөгжил сангийн орлого 700.0 сая төгрөгөөр батлагдснаас гүйцэтгэлээр 669.8 сая төгрөгийн санхүүжилт авч 30.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Хүний хөгжил сангаас иргэн бүрт олгох хишиг хувийн олголт 2013 онд 764.4 сая төгрөг олгосон нь тайлант оны санхүүжилтээс сар бүр олгох 21000 төгрөгийг 4527 иргэнд 668.1 сая төгрөг, өмнөх оны үлдэгдэлээс ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд бэлнээр 1.0 сая төгрөг олгохоос 109 иргэнд 96.3 сая төгрөгийг журмын дагуу олгосон байна.

Хүний хөгжил сангийн оны эхний үлдэгдэл 270.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд 669.8 сая төгрөгийн санхүүжилт, 2.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тооцсон хүүгийн орлого, 0.1 сая төгрөгийн дэвтэрийн орлого, бусад 1.0 сая төгрөгийн, нийт 673.0 сая төгрөгийн орлого төвлөрч, иргэн бүрт олгох хишиг хувийн олголт 764.4 сая төгрөг зарцуулж, 174.4 сая төгрөгийг Хүний хөгжил сангаас хөрөнгө зарцуулах журмын 4.3-д заасны дагуу Төв төрийн сан дахь Хүний хөгжил сангийн дансанд төвлөрүүлж 2013 оны эцэст үлдэгдэлгүй байна.

2.2 Бэлэн болон бэлэн бус хэлбэрээр хишиг хувь хүртэж байгаа байдал үр нөлөөгөө үзүүлсэн ч сөрөг тал гарсан байна.

Хүний хөгжил сангийн хөрөнгийг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр хишиг хувь хүртээж байгаа нь өрх гэр бүлд орлого нэмэгдүүлэн хуримтлал бий болгоход үр нөлөөгөө үзүүлсэн байна. Энэ нь наад захын хэрэгцээнд санаа зовохгүй болсноороо сэтгэл зүйн хувьд хөдөлмөрлөх, өөрийгөө хөгжүүлэх боломжийг бий болгож байна.

Гэвч Хүний хөгжил сангаар бэлэн мөнгө олгож хишиг хувь хүртээсэн нь өрх гэр бүлийн орлого нэмэгдсэн боловч, халамжийг хавтгайруулан олгох, залуу өрх гэр бүлийг бэлэнчлэх сэтгэлгээг нэмэгдүүлэх, сөрөг үр дагаврыг бий болгоход нөлөөлсөн байна.

2.3 Хүний хөгжил сангийн хөрөнгийн хуваарилалт хуулийн дагуу явагдсан байна.

Хүний хөгжил сангийн хөрөнгийн хуваарилалт хуулийн дагуу Засгийн газрын 2010.01.06-ны №3, 2010.12.29-ний №347, 2011.08.31-ний №264, 2012.03.28-ны №96 тоот тогтоолуудыг мөрдөж 2010-2013 онуудад нийт 56747.6 сая төгрөгийг бэлэн мөнгө хэлбэрээр олгосон байна.

Он	Иргэнд сар бүр 21000 төгрөг олгох		Иргэнд 1.0 сая төгрөг олгох		Нийт дүн	
	Иргэний тоо	Хишиг хувь /сая. төг/	Иргэний тоо	Хишиг хувь /сая. төг/	Иргэний тоо	Хишиг хувь /сая. төг/
2010	62317	8917.2			62317	8917.2
2011	86713	24010.1			86713	24010.1
2012	87922	11977.7	10911	11078.2	98833	23055.9
2013	4527	668.1	109	96.3	4636	764.4
	241479	45573.1	11020	11174.5	252499	56747.6

Хүний хөгжил сангаас ажлын байр бий болгох зорилгоор 2011 онд 54 иргэний хишиг хувийн 10.0 сая төгрөгийг Төгөлдөр-тэмүүн ХХК-д шилжүүлгээр хийсэн байна.

Он	ЗГ-ын 2010.01.06-ны №3			ЗГ-ын 2010.12.29-ний №347		ЗГ-ын 2011.08.31-ний №264		ЗГ-ын 2012.03.28-ны №96
2010	70000	50000	120000	1	ЭМДШ-ийг төлөх	670000	1	Орон сууц худалдаж авсны төлбөр
2011	21000	12	252000	2	Сургалтын төлбөр төлөх	500000		Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 1.0 сая төгрөг олгох
2012	21000	6	128000	3	Ажлын байр бий болгох	10000000		
Дүн			500000					
								1000000

Бэлэн бус хэлбэрээр хүний хөгжил сангийн хөрөнгийн хуваарилалтаар сургалтын, малчин, оюутан, ажилгүй иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлд нийтдээ давхардсан тоогоор 26467 иргэнд 4985.5 сая төгрөгийн хишиг хувь бэлэн бус хэлбэрээр олгосон байна.

Он	Сургалтын төлбөр		ЭМДШимтгэл		Нийт дүн	
2011	4883	2441.5	16683	132.9	21566	2574.4
2012	4901	2411.1			4901	2411.1
Дүн	9784	4852.6	16683	132.9	26467	4985.5

2012 онд Эрдэнэс Таван толгой ХК-ийн өөрт ноогдох хувьцаагаа Засгийн газарт худалдах хүсэлт гаргасан иргэдийг бэлэн мөнгөөр, орон сууцны зээлэнд, дотроо сургалтын төлбөрт, эрүүл мэндийн даатгалд, нийгмийн даатгалын шимтгэлд гэсэн үндсэн дөрвөн сонголтоор Төв аймгийнхаа иргэдээс Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс нь хүний хөгжил сангийн дэд программд сум бүрээр нь нэгтгэн

шивж нэгтгэлийг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт /тухайн үеийн нэр/ хүргүүлсэн байна.

Саналаа өгсөн иргэдийг холбогдох төрлөөр нь харуулбал: 1.Бэлэн мөнгөөр 58217 иргэн худалдах хувьцаа 61 319 843 ширхэг, 2.Банкны зээлэнд 585 иргэн худалдах хувьцаа 623 538 ширхэг, 3.Орон сууцны зээлэнд 269 иргэн худалдах хувьцаа 283 798 ширхэг, 4.Бусад: 33 иргэн худалдах хувьцаа 27 850 ширхэг, нийт 59104 иргэн 62 255 029 ширхэг хувьцаа худалдахаар байна.

Хүний хөгжил сангийн иргэн бүрт олгох 1.0 сая төгрөгийн хишиг хувийг Аймгийн нийт иргэдийн 66.6% нь хувьцаагаа худалдаж дээрх дөрвөн сонголтоор авах хүсэлт гаргаад байна.

2013 оны Хүний хөгжил сангийн үйл ажиллагаа үр дүнтэй явагдаж байна уу?

2013 онд Хүний хөгжил сангийн олголт, зарцуулалтын байдалд дотоод хяналт болон хөндлөнгийн хяналт хийгдээгүй байна

Бүлэг 3

3.1 Сангийн хөрөнгийн зарцуулалтанд дотоод хяналт сүүлийн нэг жилд хийгдээгүй байна.

Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газраас Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс, Мэдээлэл технологийн хэлтэс болон Арилжааны банкуудтай хамтарч хүний хөгжил сангийн 2.5 жилийн олголт зарцуулалтыг тулган шалгасан байна. 2013 онд Хүний хөгжил сангийн олголт зогссон ба өмнөх оны үлдэгдэл нь олгогдоогүй мөнгийг энэ онд олгосон бөгөөд дотоод хяналт болон хөндлөнгийн ямар нэгэн хяналт хийгдээгүй байна.

Төв аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтний тайлан болон хэлтсийн дотоод хяналтын 2013 оны ажлын тайланд Хүний хөгжил сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын талаар хийсэн ажил байхгүй байна.

Хүний хөгжил сангийн тайланд жил бүр санхүүгийн тайлангийн аудит хийгдэж зөрчилгүй дүгнэлт авч ажилласан байна.

3.2 Өмнөх аудитаар тавигдсан актыг бүрэн төлж, өгсөн зөвлөмж биелүүлж ажилласан байна.

Хүний хөгжил сангийн үйл ажиллагаанд аудит хийгдэж 2012 онд Хүний хөгжил сангийн дансны үлдэгдэлд гэрээгээр зааснаас дутуу тооцож хүүг төвлөрүүлээгүй байсан 135.0 мянган төгрөгийг тухайн санд төвлөрүүлэх төлбөрийн акт тавигдаж бүрэн хэрэгжсэн байна.

2011 оны Хүний хөгжил сангийн санхүүгийн тайланд аудит хийгдэж дараах 2 зөвлөмжийг өгч хэрэгжилтийг тайлагнаж ажилласан байна.

- Байгууллагын зардлын гүйцэтгэл бодитой бус тайлагнагдах нь төсвийн төлөвлөгөөг хийх, хянах, батлах, шинжилгээ судалгааны дүнд нөлөөлөх тул зардлыг санхүүгийн тайланд НББОУС-ын дагуу үнэн зөв тайлагнаж байх
- Банкинд дамжуулсан файлуудыг банкны зарлагын гүйлгээтэй сар бүр тулган хүлээн авч зөрүү гарсан тохиолдолд хэн буруутай этгээдэд хариуцлага тооцож ажиллах

2012 оны Хүний хөгжил сангийн санхүүгийн тайланд аудит хийгдэж дараах 2 зөвлөмж өгч биелэлтийг 2013 оны 7-р сарын 04-ны өдрийн 194 албан тоотоор гаргаж ирүүлсэн тодорхой ажил зохиосон байна.

- Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс нь улсын хэмжээний сангийн талаарх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах талаар дээд байгууллагадаа санал тавин хэрэгжүүлэх талаар санаачлагатай ажиллах
- Сангийн дэд сайд, НХХөдөлмөрийн дэд сайд , ХААН банкны захирал, Хадгаламж банкны захиралтай хүний хөгжил сан, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт , хишиг хувийн мөнгийг иргэдэд олгох үйлчилгээний тухай №21/04/87, №22/02/4-3/190 тоот гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах

2013 оны Хүний хөгжил сангийн санхүүгийн тайланд аудит хийгдэж дараах зөвлөмжийг хүргүүлсэн байна.

- Ахмад настай, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бэлэн мөнгө хэлбэрээр олгох хишиг, хувийн 1.0 сая төгрөгийн олголтонд хэрэглэгдсэн дансуудыг бүрэн хаах

Санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар хийсэн ажлын гүйцэтгэлийг тухай бүрдээ биелэлтийг гаргаж ажилласан бөгөөд Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн ажилтнуудаас шалтгаалахгүйгээр арилжааны банкны ажилтнуудын буруутай үйлдэлээс болж андуурагдсан гүйлгээ гарах зөрчил арилгахгүй байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН НИЙГМИЙН ХАЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС
213300 Зуунмод, Төв аймаг
Утас: Факс:

_____ 2014.04.30 № 110 _____
танай _____ -ны № _____ -т
Г АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ Г

Хүний хөгжил сангийн 2013 оны үйл ажиллагаанд нийцлийн аудитаар өгсөн тайлантай танилцлаа.

Тайлангаар өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна.

ДАРГА  Д.ЭНХБОЛД



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

- 2013 онд Хүний хөгжил сангаас 764.4 сая төгрөгийг иргэнд бэлэн мөнгөөр олгохдоо Монгол улсын иргэн хишиг, хувь хүртэх журмыг баримталж ажилласан байна.
- Иргэн бүрт олгох 1.0 сая төгрөгийн хишиг хувийг оюутан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан иргэдэд олгосон нь Төв аймгийн нийт иргэдийн 33.4 хувийг эзэлж байна.
- Хүний хөгжил сангийн санхүүгийн тайланд аудитаар өгсөн зөвлөмжийг Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс хэрэгжүүлж ажилласан байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн дарга Д.Энхболд-д зөвлөх нь:

Санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар хийсэн ажлын гүйцэтгэлийг тухай бүрдээ биелэлтийг гаргаж ажилласан бөгөөд Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн ажилтануудаас шалтгаалахгүйгээр арилжааны банкны ажилтнуудын буруутай үйлдэлээс болж андуурагдсан гүйлгээ гарах зөрчил арилгахгүй байгаад анхаарч ажиллах